









## Research Paper

<https://doi.org/10.5564/pib.v39i2.3332>

PROCEEDINGS OF  
**PIB**  
THE INSTITUTE OF BIOLOGY

## Mammalian species richness and conservation status in the Numrug Strictly Protected Area

Ganbold DOVCHINDORJ<sup>1,\*</sup> , Jargalsaikhan ARIUNBOLD<sup>2</sup> , Kolya TERBISH<sup>3</sup> ,  
Gal-Ochir BATBOLD<sup>3</sup> , Gerelkhoo ARIUNJARGAL<sup>4</sup> , Davaa LKHAGVASUREN<sup>5</sup> 

<sup>1</sup>Gobi's Great Animals Non-Governmental Organization, Ulaanbaatar, Mongolia

<sup>2</sup>School of Mathematics and Natural Sciences, Department of Biology, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

<sup>3</sup>Numrug Strictly Protected Area's Administration, Ulaanbaatar, Mongolia

<sup>4</sup>Mongolian University of Life Sciences, Ulaanbaatar, Mongolia

<sup>5</sup>Department of Biology, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

\*Corresponding author: greatgobi40@gmail.com, <https://orcid.org/0009-0004-5650-175X>

**Abstract.** The Numrug Strictly Protected Area (SPA) in eastern Mongolia serves as a unique ecological region, encompassing diverse landscapes from medium-low mountains to forests, meadows, and steppes. It was established in 1992, with subsequent expansion in 2019 to preserve the Khingan ecosystem and Manchuria's rich biodiversity. A total of 57 mammal species belonging to seven orders were identified in Numrug SPA, representing 39.3% of Mongolia's recorded mammal species after its expansion of 1.8 more in territory size and increases in habitats. Notably, 15 of these species hold regional and international endangered statuses, emphasizing the ecological significance of the area. The analysis reveals that river valleys and mountain steppes as key habitats to mammal diversity and warrants possible new species or registration in the species richness of *Chiroptera* and *Rodentia* in further.

**Keywords:** Khingan mountain, mammals, diversity, habitats, conservation

Received 31 July 2023; received in revised form 09 October 2023; accepted 24 November 2023

© 2023 Author(s). This is an open access article under the [CC BY-NC 4.0 license](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/).

### Introduction

The planning for mammals conservation, their reproduction, and appropriate management requires an understanding of their current status and legal protection in any given area [1].

Numrug SPA is located in the eastern part of Mongolia, from the western part of the Great Khingan mountain range to the Eastern Mongolian steppe.

It is the only place where one can witness the original transition from Central Asia's forest steppe to its dry steppe [2].

Here are numerous medium-low mountains like Soyolz, Bayankheer, Khanchandman, Baitsyn Undur, Chandagat, and Temeen Mountain, as well as the easternmost point of Mongolia, the "Modot Hamar" Mountain. There are also a variety of landscapes like forests, forest steppes, meadows, and steppes. More than ten lakes and tiny ponds, a well-developed water network, consists of the rivers with their streams, including the

Burin, Bolin, Galdastai, Hujirt, and Shiveet [3].

In 1992, 320,982 hectares in the Khalkhgol sum area of the Eastern province, of the low- and mid-high mountain forest and steppe region of the western part of the Khingan mountain range along the state border, were placed under special state protection with the goal of fully preserving the Khingan ecosystem as well as Manchuria's fauna and flora [2].

In addition, the Numrug Strictly Protected Area currently extends into 587,744.74 hectares after its expansion to include part of Khalkhgol Sum in Dornod Province, by Parliament Resolution No. 41 in 2019. Up to date, many foreign and local researchers have conducted research on biology, ecology, and distribution of wild mammals in this area [4-11].

This research was conducted in conjunction with the expansion of the protected area in order to update and consolidate the list of mammal species based on research reports, news, and relevant documents from our own and

other researchers in recent years, as well as to analyze their conservation status.

## Methods

Based on previous research [4] of the Institute of Biology [5], NUM [6], MSUE [7], NGO "Gobi's Great Animals" [8], [9], [10] Bioresources Ltd. [11] we have recently compiled the results of biodiversity research.

Mammal species were labeled as "observed" if they were identified by body, carcass, or life signs. It was further classified as having been captured using bird nets, cone traps, and live traps.

By comparing the communications with rangers, researchers, border guards and local residents with published sources, three species of the Soricomorpha, namely, the Eurasian least shrew (*Sorex minutissimus*), flat-skulled shrew (*Sorex roboratus*), Asian lesser white-toothed shrew (*Crocidura shantungensis*), two species of the *Rodentia*, the Eurasian Red Squirrel (*Sciurus vulgaris*) and the Mongolian Gerbil (*Meriones unguiculatus*), two species of the *Carnivora*, namely the Stoat (*Mustela erminea*), and the Mountain Weasel (*Mustela altaica*), and a total of 7 species of mammals were newly included in the list.

Also included as "potentially can be recorded" are three species including particolored bat (*Vespertilio murinus*), Asian particolored bat (*Vespertilio sinensis*), Ikonnikov's bat (*Myotis ikonnikovi*) that have not yet been recorded within the protected area's boundaries but have been found nearby.

Mammal taxonomy and Mongolian and Latin nomenclature (apart from the *Chiroptera*) compiled by N. Batsaikhan *et al.* cited "Field Guide to the Mammals of Mongolia" [12] and S.Gombobaatar *et al.* cited "Biodiversity of Mongolia: a checklist of vertebrate and in vertebrate animals" [13].

The nomenclature of the group of *Chiroptera* was cited from the work of researcher S. Dulamtseren [14].

The Red List of Mammals of the International Union for Conservation of Nature (IUCN) has reviewed the international assessment as of 31 October 2023 [15], and the regional assessment is based on the 2006 assessment [16].

The Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora, Revised List (CITES, 2023 October 31) was applied [17].

Mammal habitats were classified in general into five types: mountain steppes, river valleys, birch forests, pine forests, and human settlements.

## Results

Our field research resulted in 22 mammalian species identified by observation, 18 species captured using live traps, 4 species captured using bird nets, and 3 species captured using cone traps.

In addition, 7 species of mammals were recorded based on published data, 3 species were considered "possible to detect," and a total of 57 species of mammals from seven orders were determined to occur in the Numrug SPA (Appendix No.1).

These comprise 6 species of Soricomorpha, 7 species of *Chiroptera*, 3 species of *Lagomorpha*, 1 species of *Erinaceomorpha*, 13 species of *Carnivora*, 22 species of *Rodentia*, and 5 species of *Artiodactyla*.

Located in this small area that makes up 0.37% of Mongolia's territory, 39.3% of the 145 species of mammals recorded in our country [12] were found here.

In the reserve, 15 mammal species from four groups (more than a quarter or 26.3% of all mammal species) have regional and international endangered status.

Two species - river otter (*Lutra lutra*), moose (*Alces alces*) —are listed as "very rare" under part 7.1 of the Mongolian Law on Fauna, while three species—Asian Particoloured Bat (*Vespertilio sinensis*), brown bear (*Ursus arctos*), Red deer (*Cervus canadensis*) —are listed as "rare" mammals. The moose, brown bear, river otter, and Asian particoloured bat were the four species listed in the third edition of the Red Book of Mongolia [18].

Brown bears and river otters are listed in Appendix I of the Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora (CITES), gray wolves (*Canis lupus*), pallas's cat (*Otocolobus manul*), and eurasian lynx (*Lynx lynx*) are listed in Appendix II, and Mongolian gazelle (*Procapra gutturosa*) are listed in Appendix II of the Convention on the Conservation of Migratory Species of Wild Animals (CMS).

According to the International Union for Conservation of Nature (IUCN) criteria for assessing the degree of endangered mammals (2022), mongolian marmot (*Marmota sibirica*), endangered (EN) river otter, and mountain weasel are included in the international endangered (NT) category and assessed as not concerned (LC) 52 species, not evaluated (NE), and two species of *Chiroptera* (Appendix No. 1).

According to the regional assessment (2006), red deer is classified as critically endangered (CR), mongolian marmot, moose, mongolian gazelles are classified as "endangered" (EN). Eurasian red squirrel, corsac fox (*Vulpes corsac*), red fox (*Vulpes vulpes*), gray wolf,

eurasian lynx, pallas's cat and wild boar (*Sus scrofa*) are classified as near threatened. There were 27 species Least concern (LC), 15 species of data deficient (DD), and 4 species that were not evaluated (NE) (Appendix No.1). In other words, 46% of the mammal species in the area were classified as least concern (LC) at the regional level, and 91% were classified as LC at the international level.

The river valley was found to have the highest number of recorded species 41, taking into account the characteristics of the habitat. In contrast, 29 species were discovered in mountain steppes, 16 in birch forests, 11 in pine forests, and 7 in human settlements (Table 1). Following human settlement, 5 species of bats, house mice (*Mus musculus*), and brown rats (*Rattus norvegicus*) have been discovered in the attics of houses, bridges, old winter quarters, sheds, and border military residential buildings (Fig. 1).

According to the table, river valleys had 71.9% of all mammals and mountain steppes had 50.9%.

While *Erinaceidae* and *Carnivora* are found in only one type of habitat, *Rodentia* (86.4%) are found in two main habitats.

Table 1. Habitat types, the number of occurrences

Habitat types	Number of species	Percent
River valley	41	71.9
Mountain steppes	29	50.9
Birch forests	16	28.1
Pine groves	11	19.3
Human settlement	7	12.3
Total	57	100




Fig. 1. Habitat type and number of mammal species

## Discussion

According to previous research and published information [19], the Khingan Mountains and its surrounding area were place to 46 species of mammals, 24 of which were rodents and lagomorhs. As of update, our list contains 57 species. The discovery of the house vole (*Microtus fortis*) in 2021 [6] as a result of a joint Mongolian-German research indicates that a new species of mammal may be discovered in the protected area in the future as a result of the research. Dr. S. Dulamtseren, a zoologist, found that the Khalkh, Numrug river basin is characterized by a higher presence of East Asian mammal species compared to the forests and steppes of Daguur Mongolia [4], [5].

In Numrug SPA, fewer studies have been conducted on the *Chiroptera*. Additional research on this topic is needed, especially given the abundance of *Chiroptera* species in the Khingan Mountains, which border our country. In the regions near the Khalkh and Numrug rivers, bat species including sibirian whiskered bat (*Myotis sibirica*), eastern water bat (*Myotis petax*), david's myotis (*Myotis davidii*), and brown long eared bat (*Plecotus ognevi*) have been observed [20]. Following the taxonomic processing of brown long-eared bats collected from the Numrug River basin, *Plecotus ognevi nömörögi* subspecies was re-recorded [21]. We have added Ikonnikov's bat, particolored bat, and Asian particolored bat to the list of potential captures in future research because they are closely marked and have not yet been observed in the protected area.

For example, Ikonnikov's bat was discovered in Mongolia from the Khingan Mountains by a single individual, according to B. Bannikov [21], and it was collected by Kazakevich. But Sokolov & Orlov [22] considered that there are no records of Ikonnikov's bat in Mongolia. This species may be found in the Numrug SPA, as it has been observed on the southwest shore of Lake Buir [20]. The particolored bat can spread to the Numrug SPA because it has been observed close to the Avdrant area and the center of the Khalkhgol sum [20]. Russian researcher V. Lobachev collected Asian particolored bats from the Buir Lake area in 1979 [23]. The border stations of Burkhan, Buir, Khalkhgol sum center, and Khalkh river were all marked and taken [20]. Asian particolored bats are found in wide open plains and steppe regions; they are primarily found in the basements of buildings, bridges, sheds, and winter shelters that were inhabited by humans.

Large colonies of them nest in the attics of the border station's residential buildings in the sparsely populated

eastern part of our country. Human activities have a major impact on these synanthropic species [7].

## Conclusion

- A total of 57 mammal species from seven orders were identified, with 39.3% of Mongolia's recorded mammal species residing in this relatively small area.
- The habitat analysis revealed that river valleys and mountain steppes host the highest diversity of mammal species, indicating the importance of these ecosystems for conservation efforts. The distribution of species across different habitat types provides valuable information for future management strategies.
- Furthermore, the study highlights the necessity for ongoing research, particularly in the underexplored realm of *Chiroptera* and *Rodentia*.

## Acknowledgments

I would like to express my sincere appreciation to Numrug SPA's administration and staff for their assistance in supporting the field research.

## References

- [1] Ya Adiya, S. Dulamtseren, and G. Tsogtjargal, «In the "A" of Small Gobi Strictly Protected Area's mammalian species & conservation status», *Proc. Inst. Biol.*, vol 28, pp 105–108, 2011.
- [2] A. Namkhai, *Protected Areas of Mongolia*, 3 ed. Ulaanbaatar, Mongolia: Bit press, 2022.
- [3] Y. Batchuluun, *The physical geography of Mongolia*, First. Ulaanbaatar, Mongolia, 2020.
- [4] S. Dulamtseren, «Dornod Mongolian (Dornod Sukhbaatar province) wild mammals», *Ecosystem of Eastern Mongolia*, vol 1, pp 18–27, 2001.
- [5] S. Dulamtseren and M. Munkhsaikhan, «Mammals of Onon, Ulz and Khalkh river basins in Mongolia», *Forestry Institute*, vol 2, pp 158–162, 1996.
- [6] D. Lchagvasuren, A. Stubbe, H. Ansorge, D. Dolch, and M. Stubbe, «Beitrag zur Säugetierfauna der Ostmongolei1», *Erforsch. biol. Ress. Mongolei (Halle/Saale)*, vol 14, pp 71–94, 2021.
- [7] J. Ariunbold, M. Munkhbaatar, N. Nandin - Erdene, and D. Munkhnast, «Biology, Ecology and Conservation issues of Asian Particolored Bat (*Vespertilio sinensis*) in Eastern Mongolia», *Proceedings of the Mongolian State University of Education*, vol 3, pp 7–12, 2011.
- [8] G. Dovchindorj, «Distribution of the river otter (*Lutra lutra* linnaeus, 1758) in Numrug SPA», Ulaanbaatar, Mongolia, 2020.
- [9] G. Dovchindorj, *Ecological aspects of wild camels in Mongolia*. Ulaanbaatar, Mongolia, 2022.
- [10] G. Dovchindorj, «A brief report on the work at the Numrug SPA», Ulaanbaatar, Mongolia, 2023.
- [11] G. Dovchindorj, «Forest ungulates survey of Numrug SPA», Ulaanbaatar, Mongolia, 2018.
- [12] N. Batsaikhan, S. Shar, D. Lkhagvasuren, S. R. B. King, and R. Samiya, *A field guide to the mammals of Mongolia*, 3 ed. Ulaanbaatar, Mongolia, 2022.
- [13] S. Gombobaatar, S. Shar, U. Aibek, G. Gerelmaa, and S. Bayarkhuu, *Biodiversity of Mongolia: A checklist of vertebrate and invertebrate animals*, vol 1. Ulaanbaatar, Mongolia, 2019.
- [14] S. Dulamtseren, «Mongolian names of mammal taxonomy and systematics (Latin-Mongolian-English-Russian)», *Proceedings of the State Nomenclatural Commission*, vol 148, pp 3–72, 2003.
- [15] IUCN, «IUCN Red List of Threatened Species. Valid October 30, 2023, from <https://www.iucnredlist.org>.» 2023.
- [16] E. L. Clark *et al.*, *Mongolian Red List of Mammals*, vol Regional Red List Series Vol. 1. Ulaanbaatar, 2006.
- [17] CITES, «Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora (CITES), Appendices I, II, and III». 2023.
- [18] T. Shiirevdamba, *Mongolian Red Data Book*. Ministry of Environment and Green Development. Ulaanbaatar: ADMON Printing, 2014.
- [19] E. Tuguldur, «Management Plan for Numrug SPA (2014-2018)», 2013.
- [20] J. Ariunbold, «Comprehensive studies of species composition, distribution and some biological issues of Mongolian Vesper Bats», Ph.D. Thesis, Mongolian National University of Education, 2018.
- [21] A. G. Bannikov, *Mammals of the People's Republic of Mongolia*. Moscow, 1954.
- [22] V. E. Sokolov and V. N. Orlov, *Identification Key to the Mammals of the Mongolian People's Republic*. Moscow: Nauka Press, 1980.
- [23] I. Horaček, «Status of *Vesperus sinensis* Peters, 1880 and remarks on the genus *Vespertilio*», *Vespertilio*, vol 2, pp 59–72, 1997.









**Appendix 1.** Mammalian species richness and conservation status in the Numrug strictly protected

№	Scientific name	IUCN Red list		Detected method	Habitat type				
		Global status, 2022	Regional status, 2006		Mountain steppes	River valleys	Birch forests	Pine groves	human settlement
<b>I</b>	<b>ERINACEOMORPHA</b>								
1	<i>Mesechinus dauuricus</i>	LC	LC	Observed	+				
<b>II</b>	<b>SORICOMORPHA</b>								
2	<i>Sorex tundrensis</i>	LC	DD	Cone traps		+			
3	<i>Sorex daphaenodon</i>	LC	LC	Cone traps		+			
4	<i>Sorex minutissimus</i>	LC	DD	Press release		+			
5	<i>Sorex roboratus</i>	LC	DD	press release		+			
6	<i>Sorex caecutiens</i>	LC	LC	Cone traps		+			
7	<i>Crocidura shantungensis</i>	LC	NE	Press release		+			
<b>III</b>	<b>Chiroptera</b>								
8	<i>Vespertilio murinus</i>	LC	LC	Potentially detectable	+	+			+
9	<i>Vespertilio sinensis</i> **	LC	DD	Potentially detectable	+	+			+
10	<i>Myotis sibirica</i>	NE	DD	Bird nets		+	+	+	
11	<i>Myotis petax</i>	NE	LC	Bird nets		+	+	+	+
12	<i>Myotis davidii</i>	LC	LC	Bird nets	+	+			+
13	<i>Myotis ikonnikovii</i>	LC	DD	Potentially detectable		+	+	+	
14	<i>Plecotus ognevi</i>	LC	LC	Bird nets	+	+	+	+	+
<b>IV</b>	<b>LAGOMORPHA</b>								
15	<i>Lepus timidus</i>	LC	LC	Observed		+	+	+	
16	<i>Lepus tolai</i>	LC	LC	Observed	+	+	+	+	
17	<i>Ochotona dauurica</i>	LC	LC	Observed	+				
<b>V</b>	<b>RODENTIA</b>								
18	<i>Marmota sibirica</i>	EN	EN	Observed	+				
19	<i>Spermophilus dauricus</i>	LC	DD	Observed	+				
20	<i>Tamias sibiricus</i>	LC	LC	Live traps		+	+		
21	<i>Sciurus vulgaris</i>	LC	NT	Press release		+	+		
22	<i>Myospalax aspalax</i>	LC	DD	Live traps	+	+			
23	<i>Myospalax psilurus</i>	LC	DD	Live traps	+	+			
24	<i>Microtus gregalis</i>	LC	LC	Live traps		+			
25	<i>Microtus fortis</i>	LC	DD	Live traps		+	+		
26	<i>Microtus maximoviczii</i>	LC	DD	Live traps		+			
27	<i>Microtus mongolicus</i>	LC	LC	Live traps		+			
28	<i>Lasiopodomys brandtii</i>	LC	LC	Live traps	+				
29	<i>Myodes rufocanus</i>	LC	LC	Live traps		+	+		
30	<i>Ondatra zibethicus</i>	LC	NE	Observed		+			
31	<i>Cricetulus barabensis</i>	LC	LC	Live traps	+	+			
32	<i>Phodopus campbelli</i>	LC	LC	Live traps				+	
33	<i>Meriones unguiculatus</i>	LC	LC	Press release	+				

34	<i>Micromys minutus</i>	LC	DD	Live traps	+	+			
35	<i>Apodemus agrarius</i>	LC	DD	Live traps		+	+		
36	<i>Apodemus peninsulae</i>	LC	LC	Live traps		+	+		
37	<i>Mus musculus</i>	LC	NE	Live traps		+			+
38	<i>Rattus norvegicus</i>	LC	NE	Live traps		+			+
39	<i>Allactaga sibirica</i>	LC	LC	Live traps	+				
<b>VI</b>	<b>CARNIVORA</b>								
40	<i>Nyctereutes procyonoides</i>	LC	LC	Observed	+	+	+	+	
41	<i>Vulpes corsac</i>	LC	NT	Observed	+				
42	<i>Vulpes vulpes</i>	LC	NT	Observed	+				
43	<i>Canis lupus</i> <sup>©II</sup>	LC	NT	Observed	+	+	+	+	
44	<i>Ursus arctos</i> <sup>**©I</sup>	LC	DD	Observed	+	+	+	+	
45	<i>Meles leucurus</i>	LC	LC	Observed	+	+	+	+	
46	<i>Lutra lutra</i> <sup>*©I</sup>	NT	DD	Observed		+			
47	<i>Mustela eversmanni</i>	LC	LC	Observed	+	+			
48	<i>Mustela nivalis</i>	LC	LC	Live traps	+				
49	<i>Mustela erminea</i>	LC	LC	Press release	+				
50	<i>Mustela altaica</i>	NT	LC	Press release	+				
51	<i>Lynx lynx</i> <sup>©II</sup>	LC	NT	Observed	+	+	+	+	
52	<i>Otocolobus manul</i> <sup>©II</sup>	LC	NT	Observed	+				
<b>VII</b>	<b>ARTIODACTYLA</b>								
53	<i>Sus scrofa</i>	LC	NT	Observed	+	+	+	+	
54	<i>Alces alces</i> <sup>*</sup>	LC	EN	Observed	+	+	+	+	
55	<i>Capreolus pygargus</i>	LC	LC	Observed	+	+	+	+	
56	<i>Cervus elaphus</i> <sup>**</sup>	LC	CR	Observed	+	+	+	+	
57	<i>Procapra gutturosa</i> <sup>#II</sup>	LC	EN	Observed	+				
<b>Notes:</b> Critically Endangered (CR), Endangered (EN), Vulnerable (VU), Near Threatened (NT), Least Concern (LC), Data Deficient (DD), Not evaluated (NE) Press release: Batsaikhan <i>et al.</i> , 2022. Field Guide to the Mammals of Mongolia. * - Mongolian Law on Fauna, 2012 **- List of rare animals, 2012 © - Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora, Revised List (CITES) # - Convention on the Conservation of Migratory Species of Wild Animals (Bonn Convention; CMS)									



## Нөмрөгийн дархан цаазат газрын хөхтөн амьтдын зүйлийн баялаг, хамгааллын статус

Ганболд Довчиндорж<sup>1,\*</sup> , Жаргалсайхан Ариунболд<sup>2</sup> , Коля Тэрбиш<sup>3</sup> ,  
Гал-Очир Батболд<sup>3</sup> , Гэрэлхүү Ариунжаргал<sup>4</sup> , Даваа Лхагвасүрэн<sup>5</sup> 

<sup>1</sup>Монгол Улс, Улаанбаатар, Говийн гайхамшигт амьтад Төрийн Бүс Байгууллага

<sup>2</sup>Монгол Улс, Улаанбаатар, Монгол Улсын боловсролын их сургууль, Математик, байгалийн ухааны сургууль, Биологийн тэнхим

<sup>3</sup>Монгол Улс, Дорнод аймаг, Нөмрөгийн Дархан Цаазат Газрын хамгаалалтын захиргаа

<sup>4</sup>Монгол Улс, Улаанбаатар, Хөдөө аж ахуйн их сургууль, Агрэкологийн сургууль, Экологийн тэнхим

<sup>5</sup>Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухааны сургууль, Байгалийн ухааны салбар, Биологийн тэнхим

\*Corresponding author: greatgobi40@gmail.com, <https://orcid.org/0009-0004-5650-175X>

**Хураангуй.** Монголын зүүн хэсэгт орших дундаж нам уулс, ой, нуга, тал хээр зэрэг олон янзын ландшафтыг хамарсан экологийн өвөрмөц нутаг Нөмрөгийн дархан цаазат газрыг Хянганы нурууны экосистем, биологийн олон янз байдлыг хадгалах зорилготой 1992 онд байгуулж, 2019 онд өргөтгөсөн. Газар нутгийн хэмжээ 1,8 дахин тэлж, амьдрах орчны олон янз байдал нэмэгдсэн учраас бид Нөмрөгийн ДЦГ-т Монгол орны хөхтөн амьтдын долоон багт хамаарах 57 зүйлийн (39.3 хувь) жагсаалтыг анх удаа тоймлов. Эдгээр зүйлийн 15 нь бүс нутгийн болон олон улсын хэмжээнд ховордлын статустай байгаа нь тухайн бүс нутгийн экологийн ач холбогдлыг илэрхийлж байна. Голын хөндий, уулын хээр нь хөхтөн амьтдын олон янз байдалд чухал төдийгүй гар далавчтан болон мэргэгчдийн зүйлийн баялгийн судалгааг нарийвчлан хийвэл энд шинэ зүйл нэмэгдэх боломжтой.

**Түлхүүр үгс:** Хянганы нуруу, хөхтөн, олон янз байдал, амьдрах орчин, хамгаалал

Хүлээн авсан 2023.07.31; хянан тохиолдуулсан 2023.10.09; зөвшөөрсөн 2023.11.24

© 2023 Зохиогчид. [CC BY-NC 4.0 лиценз](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/).

### Оршил

Аливаа газар нутгийн хөхтөн амьтдын өнөөгийн статус, хууль эрх зүйн баримт бичгээр хамгаалагдсан байдлыг тодруулан үзэх нь тэдгээрийг хамгаалах, өсгөн үржүүлэх, зүй зохистой менежментийг төлөвлөхөд чухал ач холбогдолтой [1].

Нөмрөгийн Дархан Цаазат Газар (ДЦГ) нь Монгол орны зүүн хязгаар Их Хянганы нурууны баруун хэсгийг дамнан Дорнод Монголын хээрт түрж орсон зурвас нутгийг хамран оршдог.

Энэ бүс нутаг монгол оронд өөр хаана ч байхгүй зүүн хойд Азийн өргөн навчит ойн биомын төлөөлөлтэй. Ойт хээрээс Төв Азийн хуурай хээрт шилжих шилжилтийн онцлогийг онгон төрхөөр нь үзэж танилцах боломжтой цорын ганц нутаг юм [2].

Энд Монгол орны зүүн захын цэг Модтой хамар уулнаас гадна, Соёлз, Баянхээр, Ханчандмань, Байцын өндөр, Чандагат, Тэмээн уул зэрэг дундаж нам уулс элбэг, ой, ойт хээр, нуга, нугат хээр, хээр

гэсэн олон янзын ландшафтыг өөртөө багтаасан, Дэгээ, Нөмрөг голууд тэдгээрийн цуггал болох Бурийн, Болийн, Галдастай, Хужирт, Шивээт зэрэг гол горхитой, 10 гаруй нууртай, жижиг цөөрөм элбэг, усан сүлжээ сайтай [3] нутаг.

1992 онд Улсын Бага Хурлын 11 дүгээр тогтоолоор Дорнод аймгийн Халхгол сумын нутагт улсын хилийн дагуу Хянганы нурууны баруун хэсгийн нам ба дундаж өндөр уулсын ойт хээр, хээрийн мужид 320 982 га талбайг эзлэн орших нутгийг Хянганы экосистем, Манжуурын амьтан, ургамлын аймгийг иж бүрдлээр хамгаалах зорилготойгоор улсын тусгай хамгаалалтад авч Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолоор Дархан цаазат газрын ангиллаар баталгаажуулсан [2].

Мөн УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоолоор Нөмрөгийн ДЦГ-ын хилийн заагт Дорнод аймгийн Халхгол сумын зарим хэсгийг хамруулан өргөтгөсөн, одоо 587 744.74 га талбайг хамарч байна.

Тухайн нутгийн зэрлэг хөхтний биологи, экологи, тархцын судалгааг гадаад, дотоодын олон судлаачид өнөөг хүртэл хийж гүйцэтгэсээр ирсэн [4-11].

Тус дархан газрын талбайн хэмжээг өргөтгөсөнтэй холбогдуулан хөхтөн амьтдын зүйлийн жагсаалтыг сүүлийн жилүүдэд хийсэн өөрсдийн болон бусад судлаачдын судалгааны тайлан, мэдээ, холбогдох баримт материалд үндэслэн шинэчлэх, нэгтгэх, тэдгээрийн хамгааллын статуст дүн шинжилгээ хийх зорилгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэв.

## Арга зүй

Өмнөх судлаачдын гаргасан бүтээлүүдийг [4] суурь болгон сүүлийн 20 гаруй жил Нөмрөгийн ДЦГ-т ажилласан Биологийн хүрээлэн [5], МУИС [6], МУБИС [7], “Говийн гайхамшигт амьтад” ТББ [8], [9], [10] Биоресурс ХХК [11] зэрэг олон байгууллага, судлаачдын биологийн олон янз байдлын судалгааны үр дүнг шинээр нэгтгэн оруулав.

Бид хөхтний зүйлүүдийг илрүүлсэн хэлбэрийг биеэр болон сэг зэм, амьдралын ул мөрөөр тэмдэглэсэн тохиолдолд “ажиглагдсан”, мөн амьд баригч, конус, шувууны тороор бүртгэгдсэн гэж ангиллаа.

Байгаль хамгаалагч, судлаачид, хилийн цэрэг, нутгийн иргэдийн аман мэдээг хэвлэлийн эх сурвалжтай тулган нягталж шавж идэштэн багийн өөдсөн атаахай (*Sorex minutissimus*), тавшгар атаахай (*Sorex roboratus*), азийн малтаахай (*Crocidura shantungensis*) гэсэн гурван зүйл, мэрэгчтэн багийн бараан хэрэм (*Sciurus vulgaris*), монгол чичүүл (*Meriones unguiculatus*) гэсэн хоёр зүйл, мах идэштний баг, суусрын овогт хамаарах цагаан үен (*Mustela erminea*), хээрийн солонго (*Mustela altaica*) гэсэн хоёр зүйл, нийт долоон зүйл хөхтнийг жагсаалтад нэмж оруулсан.

Дархан цаазат газрын хилийн зурвас дотор тэмдэглэгдээгүй боловч ойролцоо илэрсэн буурал (*Vespertilio murinus*) сармаахай, дорнын сармаахай (*Vespertilio sinensis*), бяцхан багваахай (*Myotis ikonnikovi*) гэсэн гурван зүйл гар далавчтаныг “илрэх боломжтой” гэж оруулав.

Хөхтөн амьтны ангилал зүй болон монгол, латин нэршлийг (гар далавчтаны багаас бусад) С.Гомбобаатар нарын эмхэтгэсэн “Монгол орны биологийн олон янз байдал: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт” [12] болон “Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага” [13] бүтээлүүдээс мөрдлөг болгов.

Гар далавчтаны багийн зүйлийн оноосон

нэршлийг С.Дуламцэрэн [14] судлаачийн бүтээлээс ишлэв.

Дэлхийн байгаль хамгаалах холбооны (IUCN) хөхтөн амьтны улаан дансны олон улсын үнэлгээг 2023 оны 10 сарын 31 байдлаар нягталж [15], бүс нутгийн үнэлгээ 2006 оны үнэлгээгээр [16] оруулав.

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын жагсаалтыг 2023 оны 10 сарын 31 байдлаар нягталж [17] ашигласан.

Хөхтний амьтдын тэмдэглэгдсэн амьдрах орчныг уулын хээр, голын хөндий, хусан ой, нарсан төгөл, хүний суурьшил гэсэн таван төрлөөр ерөнхий ангилав.

## Үр дүн

Бидний хээрийн судалгааны үр дүнд 22 зүйлийг ажиглалтаар, 18 зүйлийг амьд баригч ашиглан, дөрвөн зүйлийг шувууны тороор, гурван зүйлийг конус ашиглан барьж тодорхойлсон. Мөн 7 зүйл хөхтнийг хэвлэлийн мэдээнд үндэслэн бүртгэж, 3 зүйлийг “илрэх боломжтой” гэж үзээд нийт долоон багийн 57 зүйл хөхтөн амьтан Нөмрөгийн ДЦГ-т тохиолдож болохыг тодорхойлов (**1-р хавсралт**).

Энд зараатан багийн 1, шавж идэштэн 6, гар далавчтан 7, туулайтан 3, мэрэгчид 22, мах идэштэн 13, туруутан 5 зүйл тус тус байна.

Монгол орны нутаг дэвсгэрийн 0,37% эзлэх энэ орон зайд манай оронд тэмдэглэгдсэн 145 зүйл хөхтөн [13] амьтны 39.3% тэмдэглэгдэв.

Тус дархан газарт дөрвөн багийн 15 зүйл хөхтөн (нийт хөхтний зүйлийн дөрөвний нэгээс олон буюу 26.3%) бүс нутгийн болон олон улсын хэмжээнд ховордлын статустай байна. Үүнд: “Амьтны тухай” хуулийн 7.1 заасан нэн ховор амьтны жагсаалтад голын халиу (*Lutra lutra*), хандгай (Дорнын молцог хандгай нэрээр) (*Alces alces*) гэсэн хоёр зүйл, Монгол Улсын Засгийн газрын “Ховор амьтны жагсаалт”-д дорнын сармаахай (*Vespertilio sinensis*), хүрэн баавгай (*Ursus arctos*), халиун буга (*Cervus elaphus*) гэсэн гурван зүйл, Монгол улсын улаан номын гурав дахь удаагийн хэвлэлтэд [18] дорнын сармаахай, хүрэн баавгай, голын халиу, хандгай гэсэн дөрвөн зүйл тус тус орсон.

Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES) -ын I хавсралтад хүрэн баавгай, голын халиу, II хавсралтад саарал чоно (*Canis lupus*), мануул (*Otocolobus manul*), шилүүс (*Lynx lynx*) бүртгэгдсэн бол Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах




тухай конвенц (CMS) -ын II хавсралтад цагаан зээр (*Procapra gutturosa*) орсон.

Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны хөхтөн амьтдын ховордлын зэргийг үнэлэх шалгуураар олон улсын хэмжээнд устаж болзошгүй (EN) ангилалд монгол тарвага (*Marmota sibirica*), ховордож болзошгүй (NT) голын халиу, хээрийн солонго (*Mustela altaica*) орсон бол анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлэгдсэн 52 зүйл, үнэлгээ хийгдээгүй (NE) хоёр зүйл гар далавчтан байна.

Харин бүс нутгийн үнэлгээгээр устаж байгаа (CR) ангилалд халиун буга, устаж болзошгүй (EN) ангилалд монгол тарвага, хандгай, цагаан зээр, “ховордож болзошгүй” ангиллаар бараан хэрэм, хярс (*Vulpes corsac*), үнэг (*Vulpes vulpes*), саарал чоно, шилүүс, мануул, зэрлэг гахай (*Sus scrofa*) тус тус оржээ. Харин анхааралд өртөхөөргүй (LC) 27 зүйл, мэдээлэл дутмаг (DD) 15 зүйл, үнэлгээ хийгээгүй (NE) дөрвөн зүйл байна (1-р хавсралт).

Тухайн нутгийн хөхтний зүйлийн 46% нь бүс нутгийн хэмжээнд, 91% олон улсын хэмжээнд анхааралд өртөхөөргүй (LC) гэж үнэлэгджээ.

Амьдрах орчны онцлогоор авч үзвэл голийн хөндийд хамгийн олон зүйл буюу 41 зүйл тэмдэглэгджээ. Харин уулын хээрт 29, хусан ойд 16, нарсан төгөлд 11 зүйл, хүний суурьшил дагасан бүсэд 7 зүйл тус тус бүртгэгдэв (1-р хүснэгт). Хүний суурьшил дагаж байшин барилгын дээврийн хөндий, гүүр, хуучин өвөлжөө, саравч, хилийн цэргийн 1-р хүснэгт. Амьдрах орчны төрөл, тохиолдох зүйлийн тоо



1-р зураг. Амьдрах орчны төрөл ба хөхтний зүйлийн тоо

орон сууцны байшингийн дээврийн хөндий зэрэгт гар далавчтаны 5 зүйл болон гэрийн хулгана (*Mus musculus*), бор харх (*Rattus norvegicus*) тохиолдоно (1-р зураг).

Хүснэгтээс үзэхэд нийт хөхтний 71.9% голын хөндий, 50.9 хувь уулын хээрт тэмдэглэгдэв.

Ангилал зүйн нэгжээр авч үзвэл зараатан болон шавж идэштэн нэг төрлийн амьдрах орчныг сонгон байршиж байхад мэрэгчид хоёр үндсэн амьдрах орчинд илүүтэй (86.4%) тархжээ.

Харин махчид болон туруутнууд амьдрах орчны олон янзын нөхцөлд зохицон амьдардаг байна.

### Хэлэлцүүлэг

Өмнөх судлаачдын бүтээл, хэвлэлийн мэдээ баримтад [14] дурдсанаар Хянганы нуруу, түүний орчмын нутагт 46 зүйлийн амьтан бүртгэгдсэний 24 зүйл нь мэрэгч, туулай хэлбэртнүүд байв.

Бидний шинэчлэн эмхэтгэсэн жагсаалтаар 7 багийн 57 зүйл бүртгэгдлээ.

Цаашид ч тус дархан газраас шинэ зүйл хөхтөн илэрч болохыг 2021 онд хийгдсэн Монгол – Германы хамтарсан судалгааны үр дүнд өргөөнч оготно (*Microtus fortis*) олдсон явдал илтгэн харуулж байна [6].

Нөмрөгийн ДЦГ-ын амьтны аймгийн онцлогийг амьтан судлаач, доктор С.Дуламцэрэн Халх, Нөмрөгийн голын сав нутаг нь Дагуур Монголын ойт хээр, хээртэй харьцуулахад Зүүн Азийн хөхтний зүйл илүү олон нэвтэрснээрээ ялгарна гэж тодорхойлсон [4], [5].

Нөмрөгийн дархан цаазат газарт гар далавчтаны судалгаа бага хийгджээ. Манай оронтой хил залгаа нутаг Хянганы нуруунд тэмдэглэгдсэн гар далавчтаны олон зүйлүүд байгааг анхаарч энэ талын судалгааг цаашид хийх хэрэгтэй. Ойсог багваахай (*Myotis sibirica*), хээрийн багваахай (*Myotis davidii*), уссаг багваахай (*Myotis petax*), бор соотгой (*Plecotus ognevi*) нь Халх гол, Нөмрөг голын дагуух нутагт тэмдэглэгдсэн [20]. Нөмрөг голын эргээс барьсан бор соотгойд ангилал зүйн боловсруулалт хийж *Plecotus ognevi* нөмрөг дэд зүйлийг шинээр бичсэн [21]. Одоогоор бяцхан багваахай (*Myotis ikonnikovii*), буурал сармаахай (*Vespertilio murinus*), дорнын сармаахай (*Vespertilio sinensis*) тус дархан газрын нутагт бүртгэгдээгүй боловч ойр тэмдэглэгдсэн, цаашдын судалгаагаар баригдах бүрэн боломжтой тул бид жагсаалтад нэмж орууллаа. Тухайлбал: Бяцхан багваахайг Монголд Хянганы уулсын орчмоос ганц бодгаль В. Казакевич цуглуулсан

хэмээн Банников [21] бүтээлдээ тэмдэглэсэн. Харин Соколов & Орлов нар [22] бяцхан багваахайг Монголд тэмдэглэгдээгүй гэж үзжээ. Буйр нуурын баруун урд эргээс энэ зүйлийг тэмдэглэсэн бөгөөд Нөмрөгийн дархан газрын нутагт тархах боломжтой [20]. Буурал сармаахайг Халх гол сумын төв болон Авдрант зэрэг дархан газрын ойролцоо тэмдэглэгдсэн байгаа тул Нөмрөгийн дархан газрын нутагт тархах боломжтой [20]. Дорнын сармаахайг Буйр нуур орчмоос 1979 онд ОХУ-ын судлаач В.Лобачев цуглуулсан [23]. Халх гол сумын төв, Халх гол, Бурхантын застав, Буйрын застав зэргээс барьж тэмдэглэсэн [20]. Дорнын сармаахай нь задгай уудам тал, хээрийн бүсэд голдуу хүний суурьшил дагаж байшин барилгын дээврийн хөндий, гүүр, өвөлжөө, саравчинд амьдарна. Манай орны зүүн зүгийн хүн амын суурьшил багатай нутгуудад хилийн цэргийн орон сууцны байшингийн дээврийн хөндийд олноороо үүрлэнэ. Синантропны эдгээр зүйлүүд нь хүний буруутай үйл ажиллагаанд багагүй өртдөг [7].

### Дүгнэлт

- Нөмрөгийн ДЦГ-г өргөтгөсөнтэй холбоотойгоор тус нутагт хийгдсэн сүүлийн үеийн судалгааны дүнгээр жагсаалтыг шинэчлэн долоон багт хамаарах нийт 57 зүйл хөхтөн амьтан бүртгэв. Манай орны хөхтөн амьтдын 39.3% нь энэ бага талбайд нутаглаж байна.
- Амьдрах орчны хэлбэрээр авч үзвэл голын хөндий, уулын хээр нь хамгийн олон зүйлийн хөхтний амьдрах орчин болж байна.
- Цаашид гар далавчтан, мэрэгчдийн зүйлийн баялгийн судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

### Талархал

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийг эмхэтгэн боловсруулахад дэмжлэг үзүүлж ажилласан Нөмрөгийн ДЦГ-ын хамгаалалтын захиргаа, хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

### Ашигласан бүтээл

- [1] Я. Адъяа, С. Дуламцэрэн, and Г. Цогтжаргал, «Говийн бага дархан цаазат газрын „А“ хэсгийн хөхтөн амьтдын зүйлийн бүрэлдэхүүн, хамгааллын статус», Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл, vol 28, pp 105–108, 2011.
- [2] А. Намхай, Монгол улсын тусгай хамгаалалттай нутгууд. Улаанбаатар хот, Монгол улс: Битпресс,

2022.

- [3] Е. Батчулуун, Монгол орны физик газарзүй. Улаанбаатар хот, Монгол улс: Мөнхийн үсэг ХХК, 2020.
- [4] С. Дуламцэрэн, «Дорно Монголын (Дорнод, Сүхбаатар аймгийн) хөхтөн амьтан», Дорнод монголын экосистем, vol 1-р дэвтэр, pp 18–27, 2001.
- [5] С. Дуламцэрэн and М. Мөнхсайхан, «Монгол улсын онон, улз, халх голын сав нутгийн хөхтөн», Ой ан судлалын хүрээлэн, vol 2, pp 158–162, 1996.
- [6] D. Lchagvasuren, A. Stubbe, H. Ansorge, D. Dolch, and M. Stubbe, «Beitrag zur Säugetierfauna der Ostmongolei1», Erforsch. biol. Ress. Mongolei (Halle/Saale), vol 14, pp 71–94, 2021.
- [7] Ж. Ариунболд, М. Мөнхбаатар, Н. Нандин-Эрдэнэ, and Д. Мөнхнаст, «Монгол орны дорнын сармаахай (*Vespertilio sinensis* Peters, 1880)-н тархац, биологи, экологи, хамгааллын зарим асуудал», МУБИС-ийн БУС-ийн эрдэм шинжилгээний бичиг, vol 3, 2011.
- [8] Г. Довчиндорж, «Нөмрөгийн дархан газрын голын халиу (*Lutra lutra* Linnaeus, 1758)-ны тархац, байршлын судалгааны тайлан», Улаанбаатар хот, Монгол улс, 2020.
- [9] Г. Довчиндорж, «Нөмрөгийн дархан газрын голын халиу (*Lutra lutra* Linnaeus, 1758)-ны өвлийн улирлын судалгааны тайлан», Улаанбаатар хот, Монгол улс, 2022.
- [10] Г. Довчиндорж, «Нөмрөгийн ДЦГ-г ажилласан тайлан», Улаанбаатар хот, Монгол улс, 2023.
- [11] Г. Довчиндорж, «Нөмрөгийн ДЦГ-ын ойн туруутны тооллого судалгаа», 2018.
- [12] С. Гомбобаатар, С. Шар, У. Айбек, Г. Гэрэлмаа, and С. Баярхүү, Монгол орны биологийн олон янз байдал: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт., Тэргүүн боть. Улаанбаатар хот, Монгол улс.: Монголика, 2019.
- [13] Н. Батсайхан, С.Шар, Д. Лхагвасүрэн, S. R. B. King, and P. Самъяа, Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага, 3 ed. Улаанбаатар хот, Монгол улс, 2022.
- [14] С. Дуламцэрэн, «Дэлэнтний ангилбар зүй, ангилбарын монгол нэр томъёо (латин – монгол – англи - орос)», Улсын нэр томъёоны комиссын мэдээ, vol 148, p 72, 2003.
- [15] IUCN, «IUCN Red List of Threatened Species. Valid October 30, 2023, from <https://www.iucnredlist.org>
- [16] E. L. Clark *et al.*, Монгол улсын хөхтөн амьтны

- Улаан данс, Бүс нутгийн улаан дансны цуврал., vol Боть 1. Улаанбаатар хот, Монгол улс: ADMON хэвлэлийн газар, 2006.
- [17] CITES, «Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora (CITES), Appendices I, II, and III». 2023.
- [18] Ц. Шийрэвдамба, Монгол улсын улаан ном. Улаанбаатар хот, Монгол улс., 2013.
- [19] Э. Төгөлдөр, Нөмрөгийн дархан цаазат газрын менежментийн төлөвлөгөө (2014-2018). 2013.
- [20] Ж. Ариунболд, Монгол орны гар далавчтаны (*Chiroptera* Blumenbach, 1779) зүйлийн бүрдэл, тархац, биологийн зарим асуудал. Биологийн ухааны докторын зэрэг горилсон диссертаци. 2018.
- [21] А. Г. Банников, Млекопитающие Монгольской Народной Республики, Труды Монгольской комиссии, Вып. 53. Москва: Академия наук СССР, 1954.
- [22] В. Е. Соколов and В. Н. Орлов, Определитель млекопитающих Монгольской Народной Республики, vol 350. Москва: Наука, 1980.
- [23] I. Horaček, «Status of *Vesperus sinensis* Peters, 1880 and remarks on the genus *Vespertilio*», *Vespertilio*, vol 2, pp 59–72, 1997.

**1-р хавсралт.** Нөмрөгийн ДЦГ-ын хөхтөн амьтдын зүйлийн баялаг, хамгааллын статус

№	Зүйлийн нэр	Шинжлэх ухааны нэр	ДБХХ-ны Улаан данс		Илрүүлсэн хэлбэр	Амьдрах орчны төрөл				
			Олон улсын үнэлгээ, 2023	Бүс нутгийн үнэлгээ, 2006		Уулын хээр	Голын хондуй	Хусан ой	Нарсан төгөл	Хүний суурьшил
<b>I БАГ: ЗАРААТАН ERINACEOMORPHA</b>										
1	Дагуур зараа	<i>Mesechinus dauuricus</i>	LC	LC	Ажиглагдсан	+				
<b>II БАГ: ШАВЖ ИДЭШТЭН SORICOMORPHA</b>										
2	Цармын атаахай	<i>Sorex tundrensis</i>	LC	DD	конус		+			
3	Бэсрэг атаахай	<i>Sorex daphaenodon</i>	LC	LC	конус		+			
4	Өөдсөн атаахай	<i>Sorex minutissimus</i>	LC	DD	Хэвлэлийн мэдээ		+			
5	Тавшгар атаахай	<i>Sorex roboratus</i>	LC	DD	Хэвлэлийн мэдээ		+			
6	Дааган атаахай	<i>Sorex caecutiens</i>	LC	LC	конус		+			
7	Азийн малгаахай	<i>Crocidura shantungensis</i>	LC	NE	Хэвлэлийн мэдээ		+			
<b>III БАГ: ГАР ДАЛАВЧТАН CHIROPTERA</b>										
8	Буурал сармаахай	<i>Vespertilio murinus</i>	LC	LC	Илрэх боломжтой	+	+			+
9	Дорнын сармаахай**	<i>Vespertilio sinensis</i>	LC	DD	Илрэх боломжтой	+	+			+
10	Ойсог багваахай	<i>Myotis sibirica</i>	NE	DD	Шувууны тор		+	+	+	
11	Уссаг багваахай	<i>Myotis petax</i>	NE	LC	Шувууны тор		+	+	+	+
12	Хээрийн багваахай	<i>Myotis davidii</i>	LC	LC	Шувууны тор	+	+			+
13	Бяцхан багваахай	<i>Myotis ikonnikovi</i>	LC	DD	Илрэх боломжтой		+	+	+	
14	Бор соотгой	<i>Plecotus ognevi</i>	LC	LC	Шувууны тор	+	+	+	+	+
<b>IV БАГ: ТУУЛАЙТАН LAGOMORPHA</b>										
15	Чандага	<i>Lepus timidus</i>	LC	LC	Ажиглагдсан		+	+	+	
16	Бор туулай	<i>Lepus tolai</i>	LC	LC	Ажиглагдсан	+	+	+	+	
17	Дагуур огдой	<i>Ochotona dauurica</i>	LC	LC	Ажиглагдсан	+				
<b>V БАГ: МЭРЭГЧТЭН RODENTIA</b>										
18	Монгол тарвага	<i>Marmota sibirica</i>	EN	EN	Ажиглагдсан	+				
19	Дагуур зурам	<i>Spermophilus dauricus</i>	LC	DD	Ажиглагдсан	+				
20	Жирх	<i>Tamias sibiricus</i>	LC	LC	Амьд баригч		+	+		
21	Бараан хэрэм	<i>Sciurus vulgaris</i>	LC	NT	Хэвлэлийн мэдээ		+	+		
22	Дагуур номин	<i>Myospalax aspalax</i>	LC	DD	Амьд баригч	+	+			
23	Манжуур номин	<i>Myospalax psilurus</i>	LC	DD	Амьд баригч	+	+			

24	Хэргэлзий оготно	<i>Microtus gregalis</i>	LC	LC	Амьд баригч		+			
25	Өргөөнч оготно	<i>Microtus fortis</i>	LC	DD	Амьд баригч		+	+		
26	Ширгийн оготно	<i>Microtus maximoviczii</i>	LC	DD	Амьд баригч		+			
27	Монгол оготно	<i>Microtus mongolicus</i>	LC	LC	Амьд баригч		+			
28	Үлийн цагаан оготно	<i>Lasiopodomys brandtii</i>	LC	LC	Амьд баригч	+				
29	Ойн хүрэн оготно	<i>Myodes rufocanus</i>	LC	LC	Амьд баригч		+	+		
30	Заарт ондоотор	<i>Ondatra zibethicus</i>	LC	NE	Ажиглагдсан		+			
31	Хөх шишүүхэй	<i>Cricetulus barabensis</i>	LC	LC	Амьд баригч	+	+			
32	Орог зусаг	<i>Phodopus campbelli</i>	LC	LC	Амьд баригч					+
33	Монгол чичүүл	<i>Meriones unguiculatus</i>	LC	LC	Хэвлэлийн мэдээ	+				
34	Чигчий хулгана	<i>Micromys minutus</i>	LC	DD	Амьд баригч	+	+			
35	Хээрийн хулгана	<i>Apodemus agrarius</i>	LC	DD	Амьд баригч		+	+		
36	Азийн хулгана	<i>Apodemus peninsulae</i>	LC	LC	Амьд баригч		+	+		
37	Гэрийн хулгана	<i>Mus musculus</i>	LC	NE	Амьд баригч		+			+
38	Бор харх	<i>Rattus norvegicus</i>	LC	NE	Амьд баригч		+			+
39	Шивэр алагдаахай	<i>Allactaga sibirica</i>	LC	LC	Амьд баригч	+				
<b>VI БАГ: МАХ ИДЭШТЭН CARNIVORA</b>										
40	Нохой элбэнх	<i>Nyctereutes procyonoides</i>	LC	LC	Ажиглагдсан	+	+	+	+	
41	Хярс	<i>Vulpes corsac</i>	LC	NT	Ажиглагдсан	+				
42	Үнэг	<i>Vulpes vulpes</i>	LC	NT	Ажиглагдсан	+				
43	Саарал чоно <sup>©II</sup>	<i>Canis lupus</i>	LC	NT	Ажиглагдсан	+	+	+	+	
44	Хүрэн баавгай <sup>**©I</sup>	<i>Ursus arctos</i>	LC	DD	Ажиглагдсан	+	+	+	+	
45	Халздай дорго	<i>Meles leucurus</i>	LC	LC	Ажиглагдсан	+	+	+	+	
46	Голын халиу <sup>*©I</sup>	<i>Lutra lutra</i>	NT	DD	Ажиглагдсан		+			
47	Өмхий хүрнэ	<i>Mustela eversmanni</i>	LC	LC	Ажиглагдсан	+	+			
48	Хотны үен	<i>Mustela nivalis</i>	LC	LC	Ажиглагдсан	+				
49	Цагаан үен	<i>Mustela erminea</i>	LC	LC	Хэвлэлийн мэдээ	+				
50	Хээрийн солонго	<i>Mustela altaica</i>	NT	LC	Хэвлэлийн мэдээ	+				
51	Шилүүс <sup>©II</sup>	<i>Lynx lynx</i>	LC	NT	Ажиглагдсан	+	+	+	+	
52	Мануул <sup>©II</sup>	<i>Otocolobus manul</i>	LC	NT	Ажиглагдсан	+				
<b>VII БАГ: ТУРУУТАН ARTIODACTYLA</b>										
53	Зэрлэг гахай	<i>Sus scrofa</i>	LC	NT	Ажиглагдсан	+	+	+	+	
54	Хандгай*	<i>Alces alces</i>	LC	EN	Ажиглагдсан	+	+	+	+	
55	Бор гөрөөс	<i>Capreolus pygargus</i>	LC	LC	Ажиглагдсан	+	+	+	+	
56	Халиун буга**	<i>Cervus elaphus</i>	LC	CR	Ажиглагдсан	+	+	+	+	
57	Цагаан зээр <sup>#II</sup>	<i>Procapra gutturosa</i>	LC	EN	Ажиглагдсан	+				
<b>Тайлбар:</b> CR-Устаж байгаа, EN – Устаж болзошгүй, VU-Эмзэг, NT-Ховордож болзошгүй, LC-Анхааралд өргөөгүй, DD-Мэдээлэл дутмаг, NA-Үнэлэх боломжгүй, NE- үнэлгээ хийгээгүй Хэвлэлийн мэдээ: Батсайхан ба бусад, 2022. Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага * - Нэн ховор, Амьтны тухай хууль, 2012 **- Ховор, Ховор амьтны жагсаалт, 2012 ©- CITES I, II, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, хавсралт I,II #-CMS I, II, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц, хавсралт, I,II										